

## **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

### **Дорноговь аймаг Эрдэнэ сумын “ЗАЛУУЧУУД ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ТОХИЖИЛТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ АЖИЛ” ажлыг зохион байгуулах**

Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, сертификатыг хавсаргана.

Захиалагчын хяналтын зардал: 2% , магадлашгүй ажлын зардал 2%-иар, зураг төсвийн үнэ 0% төгрөгийг тус тус тооцож төсөвт тусгаж ирүүлэх.

Хэрэв зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

Гүйцэтгэсэн ажлыг ил далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

Дээрх техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу арга хэмжээ авах эрхтэй болно.

Техник, тоног төхөөрөмжийн угсралтын ажил:

- Фитнесийн тоног төхөөрөмжийг суурилуулалт, угсралтын ажлыг тоо хэмжээний дагуу чанартай хийж гүйцэтгэх.
- Тоног төхөөрөмжийг хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангаж техник, тоног төхөөрөмжийг байрлуулах.